

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-04-13

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 04 дүгээр сарын 21-ны “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

| №                                                      | Өгсөн үүрэг даалгавар                                                                                                                                                                                                                                                                              | Хариуцах эзэн                                                                          |
|--------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|
| <b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b> |                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                        |
| 1.                                                     | Нийслэлийн 204 хороонд 2025 онд хийгдсэн тохижилтын ажлын үр дүнг танилцуулах.                                                                                                                                                                                                                     | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хороод                               |
| 2.                                                     | Нийслэлийн 204 хорооны Засаг дарга нар гудамж, зам талбайг зүлэгжүүлж, тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлэх.                                                                                                                                                             | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ, Хороод |
| 3.                                                     | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/178, А/230, А/545 дугаар захирамжуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх.                                                                   | Засаг даргын орлогч, Газар зохион байгуулалтын алба                                    |
| 4.                                                     | Хүүхэд, залуучуудын хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Мопед (скүтер болон түүнтэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл)-ыг нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд хязгаарлалттайгаар оролцуулах тухай” А/387 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх. | Цагдаагийн хэлтэс                                                                      |
| 5.                                                     | Асгат, Багачууд хүнс, Хүнс хангамж, Өсвөр үе ОНӨААТҮГ-уудыгтатан буулгах эсэх, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж, сургууль, цэцэрлэгийн захирлуудтай уулзалт зохион байгуулах.                                                                                                     | Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд                |
| 6.                                                     | Шатахууны үнийн өсөлттэй холбогдуулан шатахууны хэмнэлт үүсгэн, зорчилт хөдөлгөөнийг тасралтгүй явуулж, “Улаанбаатар Смарт Карт”-тай үйл ажиллагаагаа уялдуулж, ашиг, орлого, аппликейшний хэрэглээ, цахим төлөлт зэргийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч                                             | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс                                       |

|                                                      |                                                                                                                                                                                                                   |                                                                                                                              |
|------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                      | ажиллах.                                                                                                                                                                                                          |                                                                                                                              |
| 7.                                                   | "Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, олон нийтэд тогтмол мэдээлж, нийт байгууллагууд идэвхтэй оролцох.                                                                          | Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спортын хороо                                                    |
| 8.                                                   | "1000 англи хэлний багш" хөтөлбөр боловсруулж, танилцуулах.                                                                                                                                                       | Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс                                                                                 |
| 9.                                                   | Авто замыг сэтлэх, сүвлэх, нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавьж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.                                                                                                     | Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс                                                           |
| 10.                                                  | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг тухай бүр шинэчилж, мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах. | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийт байгууллагууд                                                                      |
| <b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b> |                                                                                                                                                                                                                   |                                                                                                                              |
| 11.                                                  | Ажлын 4 өдөр шилжих бэлтгэл ажлыг хангах                                                                                                                                                                          | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс                                                                                          |
| 12.                                                  | Эрүүл мэндийн төвийн нөөц эх үүсвэрийг ашиглалтад оруулах                                                                                                                                                         | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Эрүүл мэндийн төв                                                          |
| 13.                                                  | Инженер, техникийн албан хаагчдыг үйлдвэрлэлийн талбайд ажиллах хуваарь гаргах, ажиллуулах                                                                                                                        | Багахангайн Үйлдвэр технологийн парк ХК                                                                                      |
| 14.                                                  | Нийслэлийн Засаг даргын 2026 оны "Хот, нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврын хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах     | Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс                                                           |
| 15.                                                  | Багахангай марафон-2026 УАШТ-ний бэлтгэл ажлыг хангах                                                                                                                                                             | Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс                                                                                |
| 16.                                                  | Үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн, Food Festival зохион байгуулах хугацааг тогтоох, ажлын хэсэг байгуулах                                                                                                   | Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, 2 дугаар хороо                                           |
| 17.                                                  | Нийтийн эзэмшлийн гудамж талбай, аж ахуйн нэгж байгууллагын орчны ногоон байгууламжийн усалгааг хийх                                                                                                              | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд      |
| 18.                                                  | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрлэн чимэглэл, байгууллагуудын гадна гэрэлтүүлгийн асах унтрах тохиргоог хийх                                                                                                  | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ, Холбогдох байгууллагууд |
| 19.                                                  | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тохижилтын ажлыг эхлүүлэх                                                                                                                                                       | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ                          |
| 20.                                                  | Орон нутгийн хөгжлийн сангийн санал авах ажлыг зохион байгуулах, иргэд албан хаагчдыг хамруулах                                                                                                                   | Санхүү төрийн сангийн хэлтэс, Хороод, Нийт байгууллагууд                                                                     |
| 21.                                                  | НОСК-ийн 8 айлын орон сууцтай холбоотой санал солилцох уулзалт зохион байгуулах бэлтгэл хангах                                                                                                                    | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс                                                                             |
| 22.                                                  | Хүний эрхийн үндэсний комисстой хамтран зохион байгуулах сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулах                                                                                                                 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийт байгууллагууд                                                                      |
| 23.                                                  | Сэг зэм устгах ажлыг зохион байгуулах, малчдад сэг зэмийг зөвшөөрөгдсөн цэгт                                                                                                                                      | Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Мал эмнэлгийн                                                              |

|     |                                                                                                     |                                                                                                                   |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|
|     | булшлах талаар заавар зөвлөмж өгөх                                                                  | тасаг                                                                                                             |
| 24. | Хөрөнгө оруулалтын ажлуудын ажлын даалгавруудыг бэлтгэх                                             | Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба                                                      |
| 25. | Баригдаж байгаа болон шинээр баригдах барилгын ажлуудад хяналт тавин, хэрэгжилтийг зохион байгуулах | Засаг даргын орлогч, Дүүргийн менежер, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс |
| 26. | Үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлыг уялдуулах                    | Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс                                                                     |

ТАНИЛЦСАН  
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ